

ОХУ-ААС МОНГОЛЫН ХУВЬД ЯВУУЛАЖ БҮЙ ГЕОПОЛИТИКИЙН ЗАРИМ ҮЗЭЛ САНАА

МУИС, ОУХС-ийн багш,
Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин Х.Олзвой

Монголчууд олон зууны турш Оросын геополитиктой холбоотой явж ирснийг түүх гэрчилнэ. Ер нь талын монголчууд ойн оросуудтай дайтаж найрамдаж Евразийн онолыг үндэслэгчдийн нэг П.В.Савицкий, Л.Н.Гумилевын нарын үзэж байсанчлан Евразийн геополитикийг бүрдүүлэх, Орос=heavland бий болгох хийгээд оросын ард түмний геополитикийн онцгой шинж чанарыг бүрдүүлэхэд нэн чухал хувь нэмэр оруулсан билээ. Тиймээс ч П.Савицкий "Татарчлалгүйгээр Орос байхгүй байхсан", "Орос бол их хаадыг өвлөгчид, Чингис, Төмөрийн үйл хэргийг үргэлжлүүлэгчид" гэж бичээд Өрнөд Европын далайн хүчний мэдрэхүй эх газрын зөвхөн монгол хүний мэдрэхүй адил төвшинд сөрөн зогсч байна гэсэн байдаг.

Үүний хамт Орос гүрэн бүр цагаан хаант засгийнхнаа үеэс Монгол орныг сонирхож геополитикоо боловсруулан хэрэгжүүлж ирсэн билээ. Аль XX зууны эхэнд Оросын ерөнхий сайд С.Витте Монгол нь Алс Дорнод дахь Оросын өргөжин тэлэх бодлого, Японы давар Азийн үзэлтэй мөргөлдөх газарзүй, сэтгэл санааны талбар боллоо гэж үзэж байсныг Оросын дипломатч, Монголыг судлагч Ю.Кручин 1995 онд МУИС-ийн ОУХДС-ийн зохион байгуулсан олон улсын хурал дээр тавьсан илтгэлдээ тэмдэглэж байв.²

Тэрээр илтгэлийнхээ малтай болгон тэр үеийн Оросын нэгэн сэтгүүлч М.Волосович гэгчийг иш татсан байдаг. М.Волосович А.Макиндерийн алдарт үгийг дуурайлган "Хэн Монголд давуу нөлөөтэй болно, тэрээр Төв болон Дорнод Азид, цаашилбал бүх дэлхийн бөмбөрцөг дээр тийм нөлөөтэй болно" гэж бичиж байжээ.³ Мөн Оросын цэргийн яамын сайдын үүрэг гүйцэтгэгч А.Полливанов 1911 онд П.А.Столыпинд бичихдээ хэрэв Монгол Хятадын муж болбол Хятад улс "маш урт хилээр Төв Сибирьтэй хиллэх шууд хөрш болох юм" гэж байсан бол Бээжин дэх Зөвлөлтийн төлөөлөгч И.Д.Кростовец "Монголын асуудлыг таатай бусаар шийдвэрлэх нь манай хилийн аюулгүй байдалд шууд занал учруулна" гэж бичиж байжээ.

Цагаан хаант Оросын энэ бодлогыг Зөвлөлт Оросын засгийн газар ч үргэлжлүүлсэн билээ. В.И.Ленин 1921 онд Монголын төлөөлөгчидтэй уулзахдаа Оростой холбоогүйгээр Монголын тусгаар тогтнол хангагдахгүй гэснээс гадна Монголын төлөөлөгчдийн тэмдэглэн үлдээснээс үзвэл, "...Монголын газарзүйн байрлалын улмаас империалист гүрнүүд дайн болбол манай орныг эзлэн бусад улсын эсрэг дайны үйл ажиллагаа явуулах түшиц газар болгохыг эрмэлзэх болно. Ийм учраас манай орны бүх хөдөлмөрчдийн цорын зөв зам бол Зөвлөлт Оросын ажилчин, тариачидтай холбоотойгоор төрийн ба аж ахуйн тусгаар тогтнолын төлөө тэмцэх явдал мөн" гэж Ленин хэлж байжээ.

В.Лениний энэ үг нь Монголыг өөрийн нөлөөний хүрээнд байлгахад чиглэсэн зөвлөлт төрийн гадаад бодлогын үндэс болсон юм гэж Оросын эрдэмтэн Ю.Гарушянец тэмдэглэсэнтэй⁶ санал нэг байна.

1924 оны 5 дугаар сарын 31-нд ЗСБНХУ, ДИУ-ын хоорондын асуудлуудыг зохицуулах тухай хэлэлцээр байгуулсан бөгөөд түүний тавдугаар зүйлд "...ЗСБНХУ-ын засгийн газар Гадаад Монголыг Дундад Иргэн Улсын бүрэлдэхүүн хэсэг хэмээн хүлээн зөвшөөрч тэнд Дундад Иргэн Улсын бүрэн эрхийг хүндэтгэнэ" гэж заасан нь ЗХУ, ЗХУКН бага буурай үндэстэн, түүний дотор Монголын өөртөө засах эрхийг тунхаглаж байвч хэрэг дээрээ Хаант Оросын үеийн эзэгнэгч бодлогоосоо салж чадаагүй, тэдэнтэй байгуулсан гэрээ, хэлэлцээрээ умарган араар юу ч хийж мэдэхээ харуулсан юм.

Энэ хэлэлцээрийн үндсэн нэг утга нь Монголыг өөрийн нөлөөний хүрээнд байлгахын хамт Дундад Иргэн Улстай найрсаг харилцаатай байхад чиглэсэн төрийн далд бодлогын тод илэрхийлэл байлаа.

Монгол Ардын Засгийн газар дээрх хэлэлцээрийг шаргуу эсэргүүцэж улмаар 1924 оны 11 дүгээр сард Улсын анхдугаар Их хурлаа хийж бүгд Найрамдах Монгол Ард Улсаа тунхаглаж анхдугаар Үндсэн хуулиа баталсан билээ. ЗХУ-ын де-факто хүлээн зөвшөөрөлт, ДИУ-ын нутгийн хэсгээ гэсэн үл зөвшөөрөх түрэмгий бодлогыг 1946 оны Нэгдүгээр сард эцэс болгосон юм. Гэвч Оросын геополитикийн чиглэл болох Монголыг ЗХУ-ын нөлөөнд бүрэн орж дагавар улсын байдалтай бамбай улсын хэлбэрээр байлгах бодлого хэвээр үргэлжилсэн юм. Түүний улмаас үндэсний эрх

ашгаа эрхэмлэн дээдэлдэг олон удирдагчийг зайлуулж, капиталист бус хөгжлийн зам гэгийг туршин "зөвлөлтхүүлэх", улмаар Монгол Улсыг ЗХУ, Дорнод Европоос эдийн засгийн талаар бүрэн хараат, дагавар улсын хэмжээнд хүргэсэн түүхийг энд нурун давах нь илүүц буй заа.

Энэ тухай манай түүхч эрдэмтэд, тухайлбал академич Б.Лхамсүрэн, доктор Хэрээд Л.Жамсран гэх зэрэг олон судлаач, гадаадын бусад орны эрдэмтдийн суурь судалгаанд бүрэн тусалгаа олсон билээ. 1990-ээд оноос хойш Монголын геополитик, гео-эдийн засгийн орчин эрс өөрчлөгдсөж, дагавар улсын статусаа орхиж үндэсний эрх ашгаа дээдэлсэн, үнэнхүү бүрэн эрхт, ардчилсан, зах зээлийн, нээлттэй эдийн засгийг төлөвшүүлэн тогтоох замд эргэлт буцалтгүй орсон юм.

Энэ нөхцөлд Оросын зүгээс Монголын хувьд явуулж буй бодлого зарим нэг өнгө аясын өөрчлөлттэйгөөр үргэлжилсээр байна. Үүнтэй холбогдуулан ОХУ-ын эрдэмтэд, геополитикчдын сүүлийн үед бүтээлүүдэд гарч буй үзэл санааг дор сийрүүлбэ. Эдгээр нь төрийн бодлогод онцгой нөлөө үзүүлж байгаа нь тодорхой. ЗХУ задарч, ОХУ-ын хэт их гүрний статус замхарч, дотоодын зөрчил, хямралд өртөн хүч нь суларсан нөхцөлд Монголын геостратегийн ач холбогдлыг дурдах, судлахад онцгой ач холбогдол өгч байгаа нь анзаарагдаж байна. Нөгөөтэйгүүр, БНХАУ-ын нөлөө Монголд хүчтэй болох вий гэдгээс эмзэн сэрэмжилсэн, АНУ болон бусад томоохон гүрнүүдийн сонирхол тодорхой болж буйг мэдэрсэн байдал ажиглагдах болов. Тэгэхдээ Монгол улс өнөө хэр нь эдийн засгийн хувьд Оросоос ихээхэн хараат байгаа, хэзээнээсээ Оросыг тусгаар тогтнолын баталгаа гэж түлхүү ач холбогдол өгч ирснийг ч геополитикийнхоо үндэс болгож байгаа гэж дүгнэхэд буруудахгүй. Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлалд хоёр хөрштэйгөө "бүхэлдээ" тэнцвэртэй харилцах тухай заасны утгыг ОХУ-д сайн ойлгож буй нь мэдээж.

1994 онд академич А.Арбаатов "Россия: национальная безопасность в 90-е годы" гэсэн томоохон өгүүлэл бичиж түүндээ Оросын хувьд нэн чухал асуудлын нэг бол "өнөө хэр нь ховорхон дурдагдаг Монгол Улс юм. Түүний төвийг сахисан, бүрэн эрхт байдал нь Оросын Байгалийн чанад, Казахстан болон Киргизстанд чиглэсэн Хятадын геостратегийн байрлалын үүднээс авч үзвэл

Оросын хувьд Азид аюулгүй байхын чухал хүчин зүйл болно" гэсэн дүгнэлт хийсэн билээ.

Оросын стратегийн судалгааны хүрээлэнгийн тасгийн эрхлэгч И.А.Николайчук 1995 онд МУИС-ийн ОУХДС-ийн шугамаар болсон Монголын геополитикийн өнгөрсөн үе, өнөө, ирээдүйн тухай олон улсын бага хурал дээр Монголын хувьд баримталж буй байр суурийн талаар өөрийн нь хэлснээр "Болгоомжтой, дипломат үг хэлэлтгүйгээр" дорхи санааг тодорхой илэрхийлсэн юм.⁹

Тухайлбал:

1. "Хүйтэн дайн" дуусч дэлхийн байдал өөрчлөгдөн олон улсын харилцааны шинэ тогтоц үүсч буй энэ үед Төв Азийн зүрх нь болсон Монголын геополитикийн ач холбогдол Оросын хувьд хэмжээлгүй өслөө. "Харилцаа яриагүй сайжирч байгаа ч болгоомжтой байх ёстой. Хятадын хил дээр тусгаар тогтносон Монголыг бамбай улсын хэлбэрээр хэвээр байлгах нь ямар ч нөхцөлд Орост ач холбогдолтой. Чингэхдээ найрсаг, түүнээс ч илүү (стратегийн холбоотны харилцааг хэлж байна) харилцаатай байх Монгол орныг Орос сонирхож буй нь мэдээж. Гэвч Оросын хувьд төвийг сахисан байгаа ч Монгол улс Оросын аюулгүй байдлыг хангахад нааштай үүрэг гүйцэтгэсэн хэвээр байх болно".

2. "Монгол Хятадын нөлөөний хүрээнд орох буюу эсвэл (илэрхий буюу илэрхий бус байдлаар) тусгаар тогтнолоо алдах нь бүс нутгийн байдлыг тогтвортой бус болгох хүчин зүйл гэж үзэж болох юм. Яагаад вэ гэвэл энэ нь бүс нутгийн хүчний тэнцвэрт оролцогчид, бүс нутгийн бусад улсад хохиролтойгоор нэгэнт бий болсон тэнцвэрийг өөртөө ашигтайгаар үл сууриар нь өөрчлөх оролдлого гарах боломжийг нэмэгдүүлж байна... Монгол улс хэрэг дээрээ аюулгүй байдлын олон улсын бүрэн төгс баталгаагүй үлджээ... Энэ тохиолдолд зөвхөн өргөн сурталчилсан улс төрийн тунхаглалаар хязгаарлах нь аюулгүй байдлын хуурмаг санааг л төрүүлж, тэр нь жинхэнэ асуудлыг шийдвэрлэхээс Монголын удирдагчдыг хөндийрүүлж мэдэх юм."

3. И.А.Николайчук цааш нь Монголын хувьд явуулж буй Оросын бодлого "ойр зуурын, сайн бодож боловсруулаагүй"-г шүүмжлээд үүний нь жишээ нь Оросын дээд удирдагчийн айлчлалыг яагаад ч хэрэгжүүлж чадахгүй байгаа явдал гэжээ. (2000 онд л ерөнхийлөгч В.Путин айлчлав.)

Монгол Улс, монголчууд оршдог Оросын субъектуудтай ойртож буйг тэдгээрт төвөөс зугатах хандлагыг үүсгэн Оросыг задлах гэсэн Монголын улс төрийн зарим хүчний оролдлогын илрэл гэж Москвад маш дургүйцэн ойлгож болно гэж тэрбээр анхааруулсан байна. Одоо бол арай өөр.

Ноён Н.Николайчукийн энэ илэн далангүй илтэлийн үзэл санаа улам гүнзгийрч эрдэмтэд, судлаачдын суурь бүтээл, хэвлэлд гарч энэ үндсэн дээр төр, засгийн дээд байгууллагад санаж бэлтгэгдэн Монголын хувьд ОХУ-аас явуулах ойрын болон алс хэтийн геополитик нь тодорхой болсоор байгааг тэмдэглэх нь зүйтэй. Тухайлбал, Александр Дугиний туурвисан "Основы геополитики: Геополитическое будущее России" ("Арктогея", М., 1997г.) гэсэн нэг сэдэвт томоохон бүтээлд Монголын тухай хэрхэн дурдсаныг сийрүүлбэл:

- Якут далайд гарцтай хийгээд Бурят, Монгол хил нийлж буй аваас энд цаашдаа геополитикийн зэвсэл үүсэх аюул байгаа юм. Ийм учраас Якутын өмнөд хэсэгт төлөвлөгөөтэйгөөр Оросын Баруун талын ард түмнээс нүүлгэж суурьшуулах, мөн тийм арга хэмжээг Байгаль Нуураас хойших газарт хэрэгжүүлэх; Орос-Монголын харилцааг дээд зэргээр идэвхжүүлэх хэрэгтэй. Учир нь урьжл шимгүй, бусад нөхцөлд үл ялх анхаарал татах Монгол нь энэ бүсийн геополитикийн хувьд гол, чухал нутаг дэвсгэр юм. Монгол, Хятадын хилийн дагуу, ялангуяа түүний зүүн хэсэгт Оросын цэргийн хүчтэй оролцоо байх нь Leland-ийг салгаж авах геополитикийн эрсдэлийг багасгана.¹⁰

"Оросын Өмнөд"-д дорхи бүсүүд хамаарна. Үүнд:...7) Монгол. Энэ бүсүүдэд эх газрын стратегийн хяналт тогтоосон бөгөөд эдгээр нь Өмнөд рүү цаашид хийх геополитикийн тэлэлтийн суурь байх ёстой.¹¹

Монгол бол Оросын стратегийн холбоотон. Энд урьдчилан сэргийлэх маягаар ажиллаж, Монголын улс төрийн бодлогод Хятадыг талархсан хүчин зүйлс ихсэх явдал гарлуулахгүй байх нь чухал. Монголын тал нутаг, говь цөл нь Өмнөд Сибирийг Хятадаас сайхан хамгаалдаг юм. Үүний хамт Синьзян, Төвдтэй Монголын хэлхээ холбоо идэвхжүүлэх нь зүйтэй. Эдгээр нутгаас Хятадын нөлөөг багасган шахан гаргах зорилгоор Монгол-Төвдийн холбоо байгуулах төсөл ч дэвшүүлж болох юм. Энэ холбоонд Бурят, Тува, Хакасс, Алтай Улсыг оруулж болох юм. Эд-

гээр ард түмний лалын шашин, уламжлал нь Хятадын эсрэг чиглэсэн Оросын геополитикийн стратегид чухал хэрэглүүр болно.¹² Энэ бүхнээс үзэхэд, Оросын Монгол руу чиглэсэн геополитикт өнөөгийн төвшинд хоёр гол чиглэл давамгайлж байна гэж дүгнэж болох мэт. Үүнд:

а) Монголыг Хятадын аюулаас хамгаалах бамбай (жийргэвч ч гэдэг) улсын хувьд хэвээр хадгалж нөлөөгөө тэлэх, энэ үүднээс дэлхийн болон бүсийн бусад гүрний нөлөөг хязгаарлан барих;

б) Хятадыг дэлхийн хэмжээний их гүрэн болгохгүй, тасчин хувааж хүчийг нь сулруулах, улмаар өөрийн нөлөөний хүрээнд оруулахад Монголыг геостратегийн холбоотон болгон ашиглахад оршино.

Эдгээрээс гадна манай улсын талаар бүр эсрэг байр суурьтай судлаачид, геополитикийн Орост байгааг судалгаа харуулав. Хэдэн жилийн өмнө дэлхийн шатрын аварга Гарри Каспаров Монголыг Хятадад худалдсан ч болох тухай "цуурч" манай улс төрийн зүтгэлтнүүд, ард түмний дургүйцлийг хүргэж байсан шиг яг тийм үзэлтэн ОХУ-ын удирдлагын дээд төвшинд ч мэр сэр байгаа юм. Түүний нэг нь ОХУ-ын Төрийн Дурын (анхдугаар) Геополитикийн хорооны дарга асан А.В.Митрофанов билээ. АНУ-ын эсрэг үзлийг баримтлагч энэ хүн АНД бүс дэх АНУ-ын удаан хугацааны ханжлалыг зогсооход дэлхийн тавцан дээр Орос, Хятадын хөгжлийн нэгдсэн стратеги боловсруулах хэрэгтэй гээд "Хятадыг Өрнөдийн зүг рүү тэлэн өргөжүүлэхийн тулд Орос улс газар нутгийн бүх саад тогторыг арилгах ёстой" гэх мэтээр нотлоод "... (Хятад) Монголыг авах нь 1954 онд Манжуур дахь үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой Оросын эрхээр найрсаг буулт хийсэн шиг хойд хилийн нь тухай Хятадад тайвшрах, амирлангүй байх сэтгэл төрүүлнэ..."¹³ хэмээн "Шинэ геополитикийн алхмууд" номондоо бичжээ. Үүнийг бид өөрийн бодлогодоо бодолцох ёстой.

Бидний хувьд хийх өөр нэгэн дүгнэлт гэвэл, ОХУ өнөөдөр цөмийн зэвсгийн асар их нөөцтэй, цэргийн техник технологи дээд хэмжээгээр хөгжсөндөө л их гүрний статустай, НУБ-ын Аюулгүйн Зөвлөлийн байнгын гишүүний нэг хэвээр байгаа боловч эдийн засгийн чадавхи өндөр биш, эдийн засгийн бүтэц нь жигдрээгүй, эдийн засаг-санхүүгийн байгууллагуудад нь олигархи, мафийн гэхээр сүлжээ үүссэн, улс төрийн систем нь дороос дээрээ хүртэл эцэслэн тодроогүй, субъектууд ба төвийн харилцаа хэвийн биш,

шашин, үндэстэн ястны ихээхэн зөрчилтэй, хил хязгаарын маргаан зөрчил нь шийдвэрлэгдэж дуусаагүй... зэрэг нь энэ гүрний ирээдүй геополитикийн үүднээс нэн сүүдэртэй байгаа явдал юм. Гэтэл ОХУ-д үзүүлэх АНУ-ын стратегийн дарамт шахалт хүчтэй болж, БНХАУ-ын үндэсний нийт чадавхи хурдан өсч байгаа нь манай Монголын санааг зовоохгүй байж чадахгүй. Бид бамбай улсынхаа статусыг улам бэхжүүлэх, хоёр хөршийн нөлөөний хэмжээг аль болох тэнцвэртэй байлгах талаар төрийн геополитикийн цогц бодлого боловсруулан мөрдөх хэрэгтэй гэж санагдана.

Харин ОХУ-ын ерөнхийлөгч В.В. Путин Монголд айлчилж, Азид явуулах Оросын бодлогод Монгол ач холбогдолтойг тэмдэглэн, хоёр орны харилцаанд ач холбогдол өгч буйгаа нотолсон нь манай улсын геополитикийн тэнцвэрт байдалд зохих хэмжээгээр нөлөөлөхүйц үйл явдал болсон билээ.

Тайлбар зүүлт:

1. Ю.В. Тихонравов. Геополитика М. 2000. Стр.235
2. SFS/NUM, "Mongolia's Geopolitics: Past, Present and Future", UB, 1995
3. Баабар. XX зууны Монгол: нүүдэл суудал, гарз олз... 1996, х.152
4. Ишлэлийг Г.Төмөрчулуун "Процесс принятия внешнеполитические решений в малых государствах (на примере Монголии)", "М. 1999, номоос авав, с.75-76
5. В.И. Ленин. Полн. собр. соч.-Т. 44, с. 232
6. Ю.Гарушяниц. Борьба за признание независимости Монголии. ПДВ, №2, 1997, с.113
7. См. Советско-Китайские отношения. 1917-1957. Сборник документов, М., 1959, с. 65
8. "Мировая экономика и международные отношения", №9, 1994, с. 17
9. SFS/NUM "Mongolia's Geopolitics: Past, Present and Future" Report of an International Conference, Ulaanbaatar, 1995, "Старый-Хартланд" и новый мир: альтернатива-море-или межцивилизованный буфер"
10. А.Дугин. "Основы геополитики: геополитическое будущее России" М. 1997, стр. 337-338
11. Мөн тэнд. х. 343
12. А.Дугин... х. 363. Монгол-Төвдийн холбооны тухай үзэл санааг Н.А.Нартов ч дэмжиж байна. См. Н.А.
13. А.В.Митрофанов. Шаги новой геополитики, "Русский вестник", М., 1997, с. 211

ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН УЛАМЖЛАЛ БА ЧИНГИС ХААНЫ "ИХ ЗАСАГ" ЦААЗ

МУИС, ОУХС-ийн багш,
доктор (Ph.D) Д.Уламбаяр

Монгол Улс феодалын байгууллын дунд үед өрнө, дорнын хэрэгт нөлөө бүхий гүрэн болж байсан учир гадна, дотнын аянчин, жуулчид хийгээд түүхч эрдэмт мэргэдийн бичиг тэмдэглэл, шашдир түүхэнд гүн тэмдэглэгдэн үлджээ. Сайхь бүтээлүүд нь бидэнд эртний монголчуудын хууль цаазны сэтгэлгээтэй холбоотой чамлахааргүй сурвалж мэдээг лав өгүүлэх ажээ. Ер нь XIII-XIV зууны үеийн монголчуудын нийгэм, улс төрийн давхаргын түүхийг судлахад тэр цагийн хууль цаазны дурсгалууд үлэмж ач холбогдолтой. Үүнд, юуны өмнө "Их Яса" буюу "Их засаг" хэмээх Чингис хааны хуультай холбоотой мэдээ, материалуудыг хэлж болно.

Түүхч ал-Маркизи-ад-Дин, Матаки, Г.А.Масакин, Ибн-Батута, В.Вардана, Мирхованда, Григор Акнерц, ата-Малик Жувеин, Рашид-ад-Дин, нэрт жуулчин Плато Карпини, Вильгельм Рубрук, Марко Поло нар "Их засаг" хуулийн нэлээд зүйл ангийг өөрсдийн бүтээл, аян замын тэмдэглэлдээ тусгасны гадна мөн алтан ургийнхны нууц түүх "Монголын нууц товчоон"-д энэ тухай өгүүлдэг.

"Их засаг" хуулийг судлах талаар нэрт эрдэмтэд (Г.В.Вернадский, В.В.Бартольд, Б.Я.Владиморов, П.С.Попов, П.Бережин болон бусад) ихэд анхаарч, бүтээлүүддээ онцлон тэмдэглэж байжээ. Харин проф. В.А.Рязановский энэ ажилд тусгайлан зүтгэл гаргаж, олон сурвалж материалуудыг шүүрдсэний үндсэн дээр "Монголын эрх зүй, хэв ёс" (1931), "Чингис хааны Их Яса" (1933) хэмээх томоохон хоёр номыг Харбин хотноо хэвлүүлсэн нь энэ чиглэлээр гарсан бүтээлүүдийн оргил болсон байна. Академич Ш.Нацагдорж, Ш.Бира, сурвалжлагч гишүүн Х.Пэрлээ нар ч бүтээлүүддээ асуудлыг хөндсөн нь бий.

¹ Хориг, цааз гэсэн утгатай үг ажээ.